



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амгын гудамж, Сойлын тов өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.03.15 № 602
тгний _____-ны № _____-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.ГАНБААТАР
ТАНАА

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан,
санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 24. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002031744



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амгын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023. 03. 15 № 604
танай _____-ны № _____-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.ГАНБААТАР
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 27,389.2 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002031045

© Khumar 2023. All Rights Reserved. 2023.03.15. Dushoon, Tsevi 5.4th floor



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/90/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

"Бэст фортуна аудит" ХХК-ийн
захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465

Аудитын менежер: Б.Нарангэрэл
Утас: 99839547

Ахлах аудитор: Б.Даваахүү
Утас: 99095580

Аудитор: Н.Эрдэнэбат
Утас: 99136001

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэст фортуна аудит" ХХК
Утас: 324348, 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.03.15 № 603
танай _____-ны № _____-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
О.ГАНБААТАР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 41 дугаартай "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ОНӨААТҮГ-уудын нийгмийн даатгалын өрийг шийдвэрлэх тухай" тогтоолоор өмнөх онуудад үүссэн нийгмийн даатгалын 1,600,000.0 мянган төгрөгийг өрийг барагдуулахад 2022 оны татаас санхүүжилтийн орлогыг урьдчилан олгосон байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Нийслэлийн засаг даргын 2022 оны 2 дугаар сарын А/157 дугаар "Өр төлбөр барагдуулах тухай" захирамжаар тус газрын он дамжсан шатахууны өрийг барагдуулахад Нийслэлийн 2022 оны батлагдсан төсвөөс 1,926,605.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Тайлант хугацаанд удирдлагын хэрэгцээнд худалдан авсан бараа материал болон зарим ажил үйлчилгээг холбогдох материалын данс болон тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн тул цаашид Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн яамны холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах нь зүйтэй.

2022 онд орлогын нэг төгрөгт ноогдох зардлыг 1.25 төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 1.36 төгрөгийн зардал гаргаж 0.12 төгрөгөөр зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газар нь тайлант онд нийтийн тээврийн 13 чиглэлд 35 их багтаамжийн автобус, 25 дунд оврын автобус, 46 цахилгаан автобус нийт 106 хөдлөх бүрэлдэхүүнтэй нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн.

Нийтийн тээврийн 13 чиглэлд 335,360.65 шугам/цаг ажиллахаар төлөвлөснөөс 299,346.2 шугам/цаг ажиллаж 89,3 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, Нийтийн тээврийн газартай байгуулсан гэрээг "бүрэн хангалттай" үнэлүүлсэн байна.

Тайлант онд 5 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 94 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	246,364,689.67	216,687,310.53
1.1.2	Дансны авлага	53,038,892.37	162,187,908.75
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	5,830,810.04	
1.1.6	Бараа материал	1,123,474,991.02	1,161,638,689.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,167,628,506.24	95,806,289.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,596,337,889.34	1,638,320,198.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,846,168,803.13	24,497,005,849.70
1.2.2	Биет бус хөрөнгө	277,297,325.00	275,626,700.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,123,464,128.13	24,772,632,549.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,719,802,017.47	26,408,952,747.85
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,613,874,140.54	940,382,601.52
2.1.1.2	Цалингийн өглөг	4,439,466.78	
2.1.1.3	Татварын өр	824,870,546.83	832,140,764.14
2.1.1.4	НДШ – ийн өглөг	2,507,754,927.43	1,670,646,793.98
2.1.1.6	Хүүний өглөг	98,151,943.66	61,504,483.55
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,110,070,075.85	14,370,244,373.15
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	31,056,727.17	2,547,966.21
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,190,217,828.26	17,877,486,982.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	24,922,463,454.26	17,336,521,296.05
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	24,922,463,454.26	17,336,521,296.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	35,112,681,282.52	35,213,988,278.60
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	2,065,596,348.11	2,065,596,348.11
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	292,516,631.66	287,248,984.38
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	275,626,700.00	275,626,700.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(13,026,618,944.82)	(11,433,507,563.24)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(10,392,879,265.05)	(8,805,035,530.75)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,719,802,017.47	26,408,952,747.85

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,504,630,473.65	13,974,254,014.70
2	Борлуулалтын өртөг	11,748,029,046.13	15,147,146,055.51
3	Нийт ашиг(алдагдал)	(243,398,572.48)	(1,172,892,040.81)
8	Бусад орлого	1,898,752,900.00	7,033,457,306.99
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,464,653,449.47	2,020,232,552.58
11	Санхүүгийн зардал	1,768,507,600.10	1,749,777,989.00
12	Бусад зардал	415,959,039.96	267,614,362.51
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,289.44)	(8,244,685.69)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(25,242,610.88)	(14,503,123.84)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,019,012,662.33)	1,800,192,552.56
19	Орлогын татварын зардал	-	219,726,427.63
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,019,012,662.33)	1,580,466,124.93
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,019,012,662.33)	1,580,466,124.93
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(2,019,012,662.33)	1,580,466,124.93
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12- р сарын 31- ний үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	1,085,126,700.00	(11,007,606,282.49)	(7,564,366,602.72)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	1,085,126,700.00	(11,007,606,282.49)	(7,564,366,602.72)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,019,012,662.33)	(2,019,012,662.33)
5	Бусад далгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			(809,500,000.00)		(809,500,000.00)
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2021 оны 12- р сарын 31- ний үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	275,626,700.00	13,026,618,944.82)	(10,392,879,265.05)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				12,645,258.65	12,645,258.65
11	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	275,626,700.00	(13,013,973,688.17)	(10,380,234,008.40)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,580,466,124.93	1,580,466,124.93
13	Бусад далгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт					-
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,267,647.28)			(5,267,647.28)
17	2022 оны 12- р сарын 31- ний үлдэгдэл	2,065,596,348.11	287,248,984.38	275,626,700.00	(11,433,507,563.24)	(8,805,035,530.75)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,870,097,167.56	29,665,117,010.15
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,380,341,220.34	2,061,352,576.12
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	27,532,977.40	48,342,865.80
	Татаас, санхүүжилтийн орлого	9,415,912,808.00	18,553,402,581.50
	Бусад мөнгөн орлого	46,310,161.82	9,002,018,986.73
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,216,723,821.37	17,433,888,368.84
	Ажиллагчдад төлсөн	3,348,733,419.88	4,088,665,991.43
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	367,896,338.11	2,049,572,532.57
	Бараа материал худалдан авахад төлсөн	261,628,481.80	563,107,984.00
	Ашиглалтын зардалд төлсөн	205,121,109.59	1,272,613,094.96
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,213,195,527.87	6,313,649,454.10
	Хүүний төлбөрт төлсөн	1,209,595,999.33	1,799,951,760.82
	Татаарын байгууллагад төлсөн	166,484,165.16	683,734,553.81
	Даатгалын төлбөрт төлсөн	65,669,340.00	110,175,090.00
	Бусад мөнгөн зарлага	1,378,399,439.63	552,417,907.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	653,373,346.19	12,231,228,641.31
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,611,796,717.76	6,211,658,610.57
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,611,796,717.76	6,211,658,610.57
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,611,796,717.76)	(6,211,658,610.57)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,311,796,717.76	3,759,729,239.64
	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	12,311,796,717.76	3,759,729,239.64
	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	464,948,044.64	9,808,976,649.52
	Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	464,948,044.64	9,809,004,733.79
	Бусад	-	(28,084.27)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,846,848,673.12	(6,049,247,409.88)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,111,574,698.45)	(29,677,379.14)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,357,939,388.12	246,364,689.67
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	246,364,689.67	216,687,310.53

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны мянган төгрөгөөр			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Шугамын орлого	2,286,000.0	3,965,930.4	2,067,742.3	1,898,188.1	52.1
2	Орлого зардлын зөрүү санхүүжилт	6,718,548.1	11,342,909.4	10,195,495.1	1,147,414.3	89.9
3	Нөхөн олговор/ хөнгөлөлттэй зорчигчид/	643,767.0	2,001,689.9	1,682,903.1	318,786.8	84.1
4	Түрээсийн орлого	1,734.0			-	
5	Үйл ажиллагааны бусад орлого	21,145.0	60,000.0	146,184.9	(86,184.9)	243.6
6	Хөрөнгө оруулалтын орлого	3,732,190.7	6,915,385.9	6,915,385.9	-	100.0
1. Нийт орлого		13,403,384.8	24,285,916.6	21,007,711.3	3,278,204.3	86.5
1	Цалин	4,209,802.5	6,522,698.2	5,002,001.4	1,520,696.8	76.7
2	НДШ	588,161.2	911,018.8	674,520.3	236,498.5	74.0
3	Шатахуун	2,680,901.2	3,829,430.0	3,123,575.0	705,855.0	81.6
4	Тосолгооны материал	175,525.3	244,468.5	272,833.7	(28,365.2)	111.6
5	Салбар хэрэгсэл	1,028,705.8	1,830,000.0	1,314,447.3	515,552.7	71.8
6	Дугуйн зардал	72,352.3	169,000.0	123,113.1	45,886.9	72.8
7	Хөдөлмөр хамгаалал	56,776.8	180,722.0	32,213.2	148,508.8	17.8
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,479,029.4	4,372,297.2	4,693,555.7	(321,258.5)	107.3
9	Бичиг хэрэг	19,126.6	44,561.0	33,087.3	11,473.7	74.3
10	Хангамжийн зардал	80,054.7	85,930.0	75,465.5	10,464.5	87.8
11	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	230,679.4	71,884.0	25,105.5	46,778.5	34.9
12	Засвар үйлчилгээ	10,187.5	41,300.0	1,036.0	40,264.0	2.5
13	Цахилгаан	147,132.3	478,525.0	587,843.4	(111,118.4)	123.3
14	Ус	8,136.6	30,000.0	11,165.0	18,835.0	37.2
15	Халаалт дулаан	51,314.9	22,500.0		22,500.0	-
16	Харилцаа холбоо	10,487.1	15,152.0	10,316.1	4,835.9	68.1
17	Газрын төлбөр	2,094.6	2,094.2	2,402.7	(308.5)	114.7
18	Тээврийн хэрэгслийн татвар	14,383.5	20,848.2	15,488.1	5,360.1	74.3
19	Даатгалын үйлчилгээ	45,546.1	120,000.0	121,428.6	(1,428.6)	101.2
20	Албан томилолт				-	-
21	Сургалт сурталчилгаа	9,943.7	246,500.0	8,180.6	238,319.4	3.3
22	Тэтгээр тэтгэмж, шагнал	122,037.7	125,000.0	123,434.2	1,565.8	98.7
23	Гадны үйлчилгээ	150,774.0	123,042.8	246,845.9	(123,803.1)	200.6
24	Түрээсийн зардал	354,000.0	708,000.0	678,000.0	30,000.0	95.8
25	Үйл ажиллагааны бусад	53,543.7	-	259,134.4	(259,134.4)	
26	Урт хугацаат эзэлийн хүүгийн зардал	1,796,453.9	1,465,520.0	1,749,776.0	(284,258.0)	119.4
27	Гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдал	4.3		8,244.7	(8,244.7)	
28	Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	25,242.6		14,503.1	(14,503.1)	-
2. Нийт зардал		15,422,397.5	21,658,491.8	19,207,818.8	2,450,673.0	88.7
3. Нийт ашиг/алдагдал		(2,019,012.7)	2,627,423.8	1,800,192.5	827,231.3	68.5
Орлогын нэг төгрөгт ногдох зардал		1.15	1.25	1.36	-	0.12

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 126 дугаар тогтоолоор анх үүсгэн байгуулагдаж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 73 дугаар тогтоолоор Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас салж “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын зорилгыг *“зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх, чанар үр дүнг дээшлүүлэх, нийслэлийн иргэд зорчигчдод шуурхай, боловсон, ая тухтай үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах, төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг дэлхийн жишигт хүргэхэд оршино.”* гэжээ.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслээр хүргэх;
- Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих;
- Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах;
- Нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, шинээр автобус, троллейбус угсрах, үйлдвэрлэх, дүүргүүдийн гэрэлтүүлгийн засвар, ашиглалтын ажлыг удирдан зохион байгуулах.

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ нь 2022 онд Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, нийтийн тээврийн үйлчилгээнд орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах, нийтийн тээврээр шуурхай боловсон, ая тухтай үйлчилгээг иргэдэд хүргэх зорилттой ажиллалаа.

3.2 “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сард шинээр батлагдсан;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;
- Нийслэлийн Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын тушаал 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/08 “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай”;
- Нийслэлийн засаг даргын захирамж 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/157 “Өр төлбөр барагдуулах тухай”;

- Нийслэлийн засаг даргын захирамж 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн № А/477 "Машин цагийн зардлын задаргаа батлах тухай";
- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 9 сарын 07-ны өдрийн 79 дугаар тогтоол "Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн батлах тухай";
- Нийслэлийн засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн А/1224 дугаар захирамж "Машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай";
- Нийслэлийн Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол "Үйлдвэрийн газрын ажилчдын үндсэн цалинг нэмж, нөхөн олгох тухай";
- Нийслэлийн Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/58 дугаар тушаал "Цалин хөлсний журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай";
- Нийслэлийн Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаал "Цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай".

Тайлант хугацаанд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын хэлтэс нь газрын даргын баталсан удирдамжийн дагуу санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, түлш, шатахуун, сэлбэг хэрэгслийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой зөрчлийг илрүүлж, зөвлөмж өгч ажилласан байна.

Тус газар нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Нийслэлийн дотоод аудитын албанаас дотоод аудит хийгддэг боловч 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

Тухайлбал: НБББББ-ыг 2018 онд боловсруулсан боловч баталсан тушаал байхгүй, дансны нэгдсэн төлөвлөгөөг үйл ажиллагааны онцлогт тохируулан бэлтгэж, кодлоогүй, зарим зүйл, заалт нь хэрэглэхэд шаардлага хангахгүй, хүчингүй болсон хууль тогтоомжийг баримталсан байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, журам, бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,689,150.7 мянган төгрөгөөр буюу 6.83 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	246,364.7	216,687.3	(29,677.4)
Авлага	58,869.7	162,187.9	103,318.2
Урьдчилж төлсөн тооцоо	2,167,628.5	95,806.3	(2,071,822.2)
Бараа материал	1,123,475.0	1,161,638.7	38,163.7
Үндсэн хөрөнгө	21,123,464.1	24,772,632.5	3,649,168.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,719,802.0	26,408,952.7	1,689,150.7
Богино хугацаат өр төлбөр	6,080,147.7	3,507,222.5	(2,572,925.2)
Урьдчилж орсон орлого	4,110,070.1	14,370,244.4	10,260,174.3
Урт хугацаат өр төлбөр	24,922,463.5	17,336,521.3	(7,585,942.2)
Өр төлбөрийн нийт дүн	35,112,681.3	35,213,988.2	101,306.9
Эздийн өмчийн дүн	(10,392,879.3)	(8,805,035.5)	1,587,843.80
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,719,802.0	26,408,952.7	1,689,150.7

Дээрх хүснэгтээс харахад балансын дансдад дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 216,687.3 мянган төгрөг болж 29,677.4 мянган төгрөгөөр буурсан нь өр төлбөрийн төлөлттэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 162,187.9 мянган төгрөг болж 103,318.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах данснуудын өөрчлөлтөөс шалтгаалжээ. Үүнд: Байгууллагаас авах авлага дансанд Агула даатгал ХХК-тай "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу 80,000.0 мянган төгрөгийн авлага, мөн халагдсан ажиллагсдаас авах авлага 40,215.7 мянган төгрөгөөр өссөн ба бусад дансны авлага 16,897.5 мянган төгрөгөөр буурсан байна. Халагдсан ажиллагсдаас авах авлага дансанд 10,763.1 мянган төгрөгийн найдваргүй авлага байна. Энэ нь 2018 онд Зорчигч тээврийн нэгтгэлээс балансаас баланст шилжиж ирсэн авлага юм.

Урьдчилж төлсөн тооцоо дансанд үлдэгдэл 2,071,822.2 мянган төгрөгөөр буурсан нь БНХАУ-ын "Нанжин голден драгон автобус" ХХК-с цахилгаан автобусыг хүлээн авсан тул 2,141,568.6 мянган төгрөгөөр хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалсан. Мөн программ хангамжийн урьдчилгаа 9,900.0 мянган төгрөгийг УТЗардал дансанд бүртгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,161,638.7 мянган төгрөг болж 38,163.7 мянган төгрөгөөр буурсан нь сэлбэг, материалыг шаардлагатай тухай бүрт нь худалдан авсан,

газрын даргын тушаалаар ашиглах боломжгүй 193,250.7 мянган төгрөгийн бараа материал, сэлбэгийг акталж, данснаас хассанаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Нэмэгдсэн үндсэн хөрөнгө: Нийслэлийн засаг даргын 2022 оны "Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай" А/1038 дугаар захирамжаар 1 давхар цахилгаан автобус 1 ширхэг, 2 давхар цахилгаан автобус 10 ширхэг нийт 11 ширхэг буюу 8,353,227.2 мянган төгрөгийн үнэтэй тээврийн хэрэгслийг Монгол улсын хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн эх үүсвэрээр худалдан авсан;

Хасагдсан үндсэн хөрөнгө: Нийслэлийн засаг даргын 2022 оны "Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга хасах тухай" А/51 дугаар захирамж болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/22 дугаартай "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй барилгыг акталж, данс бүртгэлээс хасах тухай тушаалыг тус тус үндэслэн 28,644.9 мянган төгрөгийн балансын үнэтэй 18,141.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 10,503.1 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг актлалж данснаас хассан;

Нийслэлийн засаг даргын 2022 оны "Нийслэлийн өмчийн бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах, балансаас баланст шилжүүлэх тухай" А/61 дугаар захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2022 оны "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай" А/41 дугаар тушаалыг тус тус үндэслэн Хьюндай каунти маркийн 5 ширхэг 644,499.9 мянган төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ өртөө нөхсөн тээврийн хэрэгслийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 4,691,885.0 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсан ба актлалсан хөрөнгийн хасагдсан хуримтлагдсан элэгдэл 662,641.7 мянган төгрөг байна.

Биет бус хөрөнгө дансанд өөрчлөлт гараагүй ба тайлант онд 1,670.7 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн хорогдуулга хийсэн.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3,507,222.5 мянган төгрөг болж 2,572,925.2 мянган төгрөгөөр буурсан нь Нийслэлийн засаг даргын А/157 дугаар захирамжаар нийслэлийн төсвөөс 1,926,605.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, урьд онуудад үүссэн шатахууны төлбөрийг барагдуулсан, мөн НИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын Нийгмийн даатгалын хуримтлагдсан өрийг төлөхөд 2022 оны орлого зарлагын зөрүү санхүүжилтээс 1,600,000.0 мянган төгрөгийг урьдчилан олгож нийгмийн даатгалын өглөг төлсөнтэй холбоотой болно. Мөн тайланд онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 219,726.4 мянган төгрөгийн өглөг нэмж бүртгэсэн байна.

Урьдчилж орсон орлого дансны хувьд 10,260,174.3 мянган төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Засаг даргын 094 дугаар захирамжаар 14,308,897.8 мянган төгрөгийн цахилгаан автобусны санхүүжилт орж ирсэн, эхний үлдэгдлээс 5,631,010.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 7,585,942.2 мянган төгрөгөөр буурсан нь 2021 онд үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн хүүхдийн сургуулийн автобусны 1,536,666.7 мянган төгрөгийг урт хугацаат зээлээр бүртгэснийг Нийслэлийн засаг даргын 2022 оны "Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай" А/44 дугаар захирамжаар залруулсан, тайлан онд Хөгжлийн банкнаас 3,759,729.2 мянган төгрөгийн зээл авч, нийт 9,809,004.7 мянган төгрөгийн урт хугацаат зээл төлснөөс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 8,805,035.5 мянган төгрөг болж 1,587,843.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн цэвэр ашиг 1,580,466.1 мянган төгрөг, урьд оны 12,645.3 мянган төгрөгийн бүртгэлийн алдааг залруулах бичилт хийж хуримтлагдсан алдагдлыг бууруулж бүртгэсэн, барилга данснаас хассаны дахин үнэлгээний хэрэгжсэн дүн болох 5,267.6 мянган төгрөгөөр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансныг бууруулж бүртгэснээс тус тус шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаартай "Үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт батлах тухай" тогтоолоор "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталж тайлант оны нийт орлогыг 17,370,529.5 мянган төгрөг, нийт зардлыг 21,658,491.8 мянган төгрөг, 4,287,962.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 14,092,325.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 19,207,518.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 1,800,192.5 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан.

Нийт орлогын гүйцэтгэл 14,092,325.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 3,278,204.3 мянган төгрөг буюу 18,9 хувиар тасарсан нь 2 давхар цахилгаан автобусыг оны эхэнд хүлээн авч, шугаманд гаргахаар төлөвлөсөн боловч ковидын нөхцөл байдлаас хил дээр саатсаны улмаас 2022 оны 6 дугаар сарын 01-нээс шугаманд гарч эхэлснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 19,207,518.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,450,973.0 мянган төгрөг буюу 11,3 хувиар дутуу зарцуулж ажилласан байна. Энэ нь тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт төлөвлөсөн хугацаанд хийгдээгүйгээс ажиллагсдын цалин хөлс, ЭМНДШ-ийн зардлыг 1,757,195.3 мянган төгрөг, сэлбэг, шатахууны зардлыг 1,221,407.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн ба үйл ажиллагааны бус зардал 259,134.4 мянган төгрөг, цахилгааны зардал 111,118.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 321,258.5 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын орлогыг 6,915,385.9 мянган төгрөгөөр урьдчилж орсон орлогоос хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 02 дугаар тогтоолоор орлогын нэг төгрөгт ноогдох зардлыг 1.25 төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 1.36 төгрөгийн зардал гаргаж 0.12 төгрөгөөр зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь эдийн засгийн зорилтот түвшинг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тооцоо судалгаанд үндэслэн үнэн бодитой төлөвлөөгүй, зардлын гүйцэтгэлд тавих хяналт сул зэргээс шалтгаалсан гэж үзлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж толилуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, эдийн засгийн зорилтот түвшинг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төрийн өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Бэст фортуна Аудит" ХХК-ий ахлах аудитор Б.Даваахүү, аудитор Н.Эрдэнэбат, туслах аудитор Г.Баттогтох нар гүйцэтгэж, хяналтыг "Бэст фортуна Аудит" ХХК-ийн чанарын хяналтын менежер Б.Нарангэрэл, захирал Ж.Оюунцэцэг, НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа "Бэст фортуна аудит ХХК"-д 2022 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 02/75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 15,422,396.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 231,335.9 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 173,501.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гаргаж, дараах арга хэмжээ арга хэмжээ авсан байна. Үүнд:

- Нийслэлийн засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/657 дугаартай "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" захирамжаар "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дэд даргын 2 орон тоог хассанаар 17,371.1 мянган төгрөгийн цалингийн зардалд хэмнэсэн боловч тэтгэмжийн зардалд 20,240.0 мянган төгрөг олгосон байна;
- Өндөр насны тэтгэвэрт гарсан 8 албан хаагчийн оронд нөхөн томилгоо хийгээгүйгээс 28,647.5 мянган төгрөгийн цалингийн зардлын бодит хэмнэлт гарсан;
- Дотоод хяналт шалгалт болон хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, албан бичгийн хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээ, дотоод удирдлагын систем ашигласнаар бичиг хэргийн зардлыг 11,473.7 мянган төгрөгөөр хэмнэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 24 төрлийн мэдээллийг Шилэн дансны цахим системд ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 149 мэдээллээс 126 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 207,293.4 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож, 47,279.1 мянган төгрөгийн 13 мэдээллийг мэдээлээгүй, 4 мэдээллийн хугацаа болоогүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэртэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус газрын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 28 ажлаас 14 ажлыг нээлттэй тендерээр сонгон шалгаруулж, 2 ажил дахин тендер зарлахаар хойшлогдож, 12 ажил төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цуцлагдсан байна.

Тендерт шалгарсан 14 байгууллагатай 5,563,913.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан хуулийн дагуу зохион байгуулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж 80,521.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 422.2 мянган төгрөгийн баримтыг бүрдүүлсэн;

- Удирдлагын хэрэгцээнд худалдан авсан 1,756.8 мянган төгрөгийн хүнсний материалыг бараа материалын дансаар дамжуулж бүртгээгүй, худалдан авсан баримтаар шууд зардалд бүртгэсэн, зарцуулалтын анхан шатны баримт байхгүй;
- Худалдаа хөгжлийн банкны кредит картаар дамжуулан олгосон 18,790.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулалтыг холбогдох норм, журмын дагуу тооцож зарцуулаагүй;
- Газрын даргын А/38 дугаар тушаалаар актлах шийдвэр гарсан 221,931.8 мянган төгрөгийн сэлбэгээс 178,557.7 мянган төгрөгийн сэлбэгийг данснаас хасч, 43,374.1 мянган төгрөгийн сэлбэгийг шаардах хуудсаар зарлагдсан;
- СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 184/ШШ2021/03164 дугаартай шүүгчийн захирамжаар иргэнд ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговорт 26,177.9 мянган төгрөг олгох шийдвэр гарч 16,177.9 мянган төгрөгийг олгож, үйл ажиллагааны бус зардлаар бүртгэснийг залруулж авлагаар бүртгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 2,146,013.5 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 216.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,256.9 мянган төгрөгийн урьд оны төлбөрийн актыг барагдуулаагүй 1, нийцлийн асуудлаар 2 албан шаардлага хүргүүлж, 5 зөвлөмж өгснөөс тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь, албан шаардлагын хэрэгжилт 89.1 хувьтай биелсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	216.8	1	216.8	100.0
Албан шаардлага	3	2,112,908.1	3	1,880,059.6	89.1
Зөвлөмж	5	32,888.6	5	32,888.6	100.0
Нийт дүн	9	2,146,013.5	9	1,913,165.0	96.3

Шилэн дансны мэдээлэлд өгсөн албан шаардлагын биелэлт 89.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд шилэн дансанд байрлуулсан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлнээс шалтгаалжээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, хууль журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан эсэхийг шалгах;
- Даргын хэрэгцээнд худалдан авсан хүнсний материалыг материалын дансанд орлого авч, зарцуулсан эсэхийг хянах;
- Торгууль, алданги, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн зардал зэрэг үйл ажиллагааны бус зардал гарсан эсэхийг хянах;
- Байгууллагын шинэ барилга ашиглалтад орсон эсэх, нүүлгэн шилжүүлэлт хийхтэй холбоотой нэмэлт зардал гарсан эсэхийг хянах;

- Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/41 дугаар тушаалаар акталсан Хьюндай каунти маркийн 5 ш тээврийн хэрэгслээс ашигласан хоёрдогч түүхий эдийг бүртгэж, худалдан борлуулж орлогыг бүртгэсэн эсэхийг шалгах;
- Актлагдсан сэлбэгийн устгалтаас орлого олсон эсэхийг хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,297,734.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 9,297,734.2 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлого, хөрөнгө оруулалтын орлогын 7,033,457.3 мянган төгрөгийг борлуулалтын орлогоор тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний хэсэгт орлого, зардлыг 2,238,199.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Гэрээт ажлын урьдчилгаа 9,900.0 мянган төгрөгийг ажлын гүйцэтгэлгүйгээр бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардалд бүртгэснийг авлагаар бүртгэсэн;
- Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халсны нөхөн олговорт 16,177.9 мянган төгрөгийг олгож, үйл ажиллагааны бус зардалд бүртгэснийг авлагаар бүртгэсэн.

Аудитаар нийт 77,073.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 27,389.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 49,684.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

Худалдан авсан бараа материалын 27,389.2 мянган төгрөгийн худалдан авалтын и баримт шивэгдээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 14.3.1. "анхан шатны баримт бүрдүүлэх", 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг" заалтыг хэрэгжүүлээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийсэн, ажил үйлчилгээний төлбөр шилжүүлсэн тухай бүр и баримт авч санхүүгийн баримтад хавсаргах, анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зорилтот түвшинтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 02 дугаар тогтоолоор тус газрын 2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталж, орлогын нэг төгрөгт ноогдох зардлыг 1 төгрөг 25 мөнгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 1 төгрөг 36 мөнгөний зардал гарч зардлыг 12 мөнгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж мөрдүүлэх" гэсэн заалтыг биелүүлээгүй байна.

Өсөн зөвлөмж: Байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, шугам цагийн тооцоо зэрэгт үндэслэн үнэн зөв, бодитой төлөвлөж батлуулах, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж, зорилтот түвшинг биелүүлж ажиллах.

2. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Удирдлагын хэрэгцээнд худалдан авсан 3,664.0 мянган төгрөгийн хүнсний материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн, зарцуулалтын анхан шатны баримт байхгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.3."Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ":14.3.1"анхан шатны баримт бүрдүүлэх";14.3.2 "журналд бичих 14.3.3 "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсвэл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материал бүрийг хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн бараа материалын холбогдох дансанд орлого авч, шаардах хуудсаар зарцуулах, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

3.Шатахууны тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдаа хөгжлийн банкны кредит картаар олгосон 42,020.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг тээврийн хэрэгслийн норм, замын хуудасны дагуу тооцоог бодоогүй зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх"; 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өсөн зөвлөмж: Картаар олгосон шатахууны тооцоог тээврийн хэрэгслийн норм, жолоочийн замын хуудас зэрэг анхан шатны баримтыг үндэслэн тооцоог бодох.

4. Хуучин сэлбэгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/41 дүгээр тушаалын дагуу акталсан 5 ширхэг тээврийн хэрэгслээс ашиглах боломжтой 4,000.0 мянган төгрөгийн хуучин сэлбэгийг материалын холбогдох дансанд бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өөсөн зөвлөмж: Акталсан тээврийн хэрэгслээс ашиглах боломжтой сэлбэг, хоёрдогч түүхий эдийг хуучин сэлбэг дансанд орлогоор бүртгэж, зарцуулалтад хяналт тавих, худалдан борлуулсан тохиолдолд орлогыг бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгажгүй орхогдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Т о о	Дүн	Т о о	Дүн	Т о о	Дүн	Т о о	Дүн	Т о о	Дүн	Т о о	Дүн
Орлогын далгэрэнгүй тайланд бусад орлого, хөрөнгө оруулалтын орлогыг борлуулалтын орлогоор бүртгэсэн.	1	7,033,457.3			1	7,033,457.3	1	7,033,457.3				
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний орлого, зардлыг дугуу тайлагнасан	1	2,238,199.0			1	2,238,199.0	1	2,238,199.0				
Тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалт, жолоочийн ажлын гүйцэтгэлийн програм хангамж нийлүүлэх гэрээт ажлын урьдчилгааг зардалд бүртгэсэн.	1	9,900.0			1	9,900.0	1	9,900.0				

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 184ШШ2021/03164 дугаартай шүүхийн захирамжаар иргэнд эсвэлгүй байсан хугацааны цагаан хөтөстэй тэнцэн олговорт 16,177.9 мянган төгрөг олгох шийдвэр гарч 16,177.9 мянган төгрөгийг олгох, үйл ажиллагааны бус зөрдлөөр бүртгэснийг зарцуулж эвчлээг бүртгэсэн.	1	16,177.9	1	16,177.9	1	16,177.9						
Дүн	4	9,297,734.2	4	9,297,734.2	4	9,297,734.2						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн төмөр утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/41 дугаар тушаалын дагуу акталсан 5 ш тээврийн хэрэгслээс ашиглах хуучин салбагийг бүртгэлд тусгаагүй.	1	4,000.0					1	4,000.0				
Удирдлагын хэрэгцээнд худалдан авсан хүнсний материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн, зарцуулалтын анхан шатны баримт байхгүй	1	3,664.0					1	3,664.0				
ХХБ-ны кредит картаар олгосон 42,020.0 мянган төгрөгийг шатахууны зарцуулалтыг тээврийн хэрэгслийн норм, замын хуудасны дагуу тооцро бодоогүй	1	42,020.0					1	42,020.0				
Худалдан авсан 2,211,794.3 мянган төгрөгийн бараа материалын и баримт шилвэгдээгүйгээс аудитын явцад 2,184,405.1 мянган төгрөгийн и баримтыг нөхөн шавуулсан.	1	27,389.2			1	27,389.2						

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшингээр орлогын 1 төгрөгт ноогдох зардлын 1.25 төгрөгөөр баталсан боловч, гүйцэтгэлээр 1.36 төгрөг болж 0.12 төгрөгөөр зардлыг хэтрүүлсэн.	1				1				
Дүн	5	77,073.2		1	27,389.2	4	49,684.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, зарим мэдээллийг дутуу мэдээлсэн	1	254,572.5					1	254,572.5
Дүн	1	254,572.5					1	254,572.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	254,572.5					1	254,572.5

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТОР

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Б.ДАВААХҮҮ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 200/12025404
44ТАГ- 2023/90/НН-СТН-ОНН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авсан бараа материалын 27,389.2 мянган төгрөгийн худалдан авалтын татварын и-баримтын бүрдэлгүй гүйгээг хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 14.3.1. "анхан шатны баримт бүрдүүлэх", 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг" заалтыг хэрэгжүүлээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1. "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулахгүй," заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бараа материалын хүчин төгөлдөр, иж бүрэн анхан шатны баримтыг үндэслэн тухай бүр нягтлан бодох бүртгэлд тусгаж байх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

БЭЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

ХЯНАСАН

Ж.ОЮУНЦЭЦЭГ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР
С.ГАНТӨГС